

ХҮН АМ ЗҮЙН ЦОНХ НЭЭГДЭХ ҮЕИЙН ТӨРӨЛТИЙГ ДЭМЖИХ БОЛОМЖУУД

*Б. Энхцэцэг, Доктор
Профессор, Хүн Амын Сургалт Судалгааны Төв,
Эдийн Засгийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль*

Хүн ам зүйн шилжилтийн онолын дагуу аливаа улс орны төрөлт өндөр түвшнээс бага түвшинд шилжиж байдаг. Монгол Улсад төрөлтийн бууралт явагдаж, 2005 онд хүн ам нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшингээс доогуур буюу төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) (төрөлтийн түвшин өөрчлөгдөхгүй нөхцөлд нэг эмэгтэйн амьдралын турш төрүүлэх хүүхдийн тоо) 1,95 болсон. Харин түүнээс хойш, төрөлтийн түвшин бага зэргийн өсөлттэй буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2006 онд 2,07, 2007 онд 2,34, 2008 онд 2,6, 2010 онд 2,4 болсон.

Хүн ам зүйн цонх ганц удаа нээгдээд хаагддаг үзэгдэл тул улс оронд ганц тохиолддог хүн ам зүйн энэ үзэгдлийг аль болох урт хугацаанд ашиглаж, цонх хаагдах үед тулгарах асуудлуудаас урьдчилан сэргийлэхийн тулд төрөлт, гэрлэлтийг дэмжих нь чухал гэдэг нь зүй ёсоор тавигдаж байна. Хэрвээ төрөлтийг дэмжих “зорилтот” бодлого авч хэрэгжүүлбэл **төрөлтийн бууруултыг сааруулах боломж** байгаа (McDonald, 2002) бөгөөд хэт оройтохоос өмнө арга хэмжээ авах нь үр дүнтэйг улс орнуудын туршлага харуулж байна.

ТӨРӨЛТИЙН ТҮВШИНД ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТ

Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин чиг хандлагыг авч үзвэл, хөгжингүй ба хөгжиж буй орнуудын хувьд нэлээд ялгаатай зүй тогтол ажиглагддаг. XIX зууны сүүлийн хагас хүртэл дэлхийн бүс нутгуудад хүн амын төрөлтийн түвшин харьцангуй өндөр байсан хэдий ч хөгжингүй орнуудын төрөлт урьд үеэс буурч эхэлсэн байсан юм. Дэлхийн II дайны

дараагаар олон улс орнуудад "төрөлтийн тэсрэлт" болж байхад Европын орнуудад ТНК 2.8 байсан ба үүнээс хойш тогтвортой буурсаар байна.

Хөгжиж буй орнуудын хувьд явагдаж байгаа төрөлтийн бууралт нь ерөнхийдөө харьцангуй хожуу буюу 1970-аад оноос эхэлсэн хэдий ч бүс нутаг, улс тус бүрээр өөр хоорондоо харилцан адилгүй байна. ХХ зууны эхээр Африк, Ази, Латин Америкийн ихэнх орнууд төрөлт, нас баралтын өндөр түвшинд буюу хүн ам зүйн шилжилтийн эхний үе шатанд байв. Гэвч эдгээр орнуудад одоогийн хөгжингүй орнуудыг бодвол төрөлт, нас баралтын өндөр түвшнээс харьцангуй доогуур түвшинд шилжих үйл явц буюу хүн ам зүйн шилжилт, тэр дундаа төрөлтийн шилжилт харьцангуй богино хугацаанд хурдацтай явагдаж байна.

Эдгээр орнуудын хүн ам залуу насны бүтэцтэй байгаагаас цаашид тодорхой хугацаанд өсөх боловч төрөлтийн доогуур хандлага үргэлжилбэл насжилт, хүн амын тоо тогтворжих, эсвэл буурах үзэгдлүүд хөгжингүй орнуудынхаас ч хурдацтай явагдаж болох юм.

Төрөлтийн өөрчлөлтийг дэлхийн улс орнуудаар задлан авч үзвэл ТНК буюу нэг эмэгтэйн амьдралын туршид төрүүлэх хүүхдийн тоо 1,1-7,0 хооронд байна. Африк болон Дундад Азийн зарим орнуудад ТНК дунджаар 5-7 байхад Европт дунджаар 2-оос бага байна. Тэр ч байтугай Европын хэд хэдэн оронд төрөлтийн абсолют тоо нас баралтын тооноос бага болжээ. Жишээ нь, Герман, Унгар, Молдав, Румын, Итали, Украин, Беларусь, Орос, Болгар гэх мэт. Хөгжингүй орнуудаас төрөлтийн түвшин

хамгийн өндөрт байгаа орнуудын нэг нь АНУ (ТНК=2,0) юм. Бусад хөгжингүй орнуудад ТНК 2,0-оос бага байна.

Хүснэгт 1: Дэлхийн хамгийн өндөр болон хамгийн доогуур төрөлтийн түвшинтэй улсууд, 2011 он

	Хамгийн өндөр төрөлтийн түвшинтэй орнууд	ТНК	Хамгийн бага төрөлтийн түвшинтэй орнууд	ТНК
1	Нигер	7,0	Тайвань	0,9
2	Мали	6,4	Хонг Конг, Хятад	1,1
3	Сомалиа	6,4	Макао, Хятад	1,1
4	Уганда	6,4	Сингапор	1,2
5	Бурунди	6,4	Өмнөд Солонгос	1,2
6	Афганистан	6,3	Андора	1,2
7	Замбиа	6,3	Унгар	1,3
8	Конгогийн Б.Н.Улс	6,1	Сан Марино	1,3
9	Чад	6,0	Молдав	1,3
10			Португал	1,3

Эх сурвалж: PRB, 2011 World population data sheet

Хүн ам зүйчид хүн амын хэтийн тооцоо хийхдээ өнгөрсөн олон арван жилийн туршид тэдгээр орнуудын олонхид нь төрөлтийн түвшин буурч ирсэнтэй адилаар цаашид ч буурна гэж голдуу төсөөлдөг. Өнгөрсөн жилүүдэд хийгдсэн тооцоонуудаас харахад төрөлтийн түвшин “нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшин”-д буюу ТНК нь 2 орчимд тогтворжино гэж төсөөлсөн байдаг. ТНК нь 2 гэсэн энэхүү түвшинд хүн амын тоо хэмжээ ерөнхийдөө тогтворждог байна.

Хүн ам зүйн шилжилтийн онолын дагуу хүн амын төрөлтийн түвшин түүхэн цаг хугацааны туршид буурсан ч нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшингээс доош очихгүй гэж байсан бол өнөөгийн Европын улс орнуудын төрөлт үүнийг биелэх албагүй гэдгийг харуулж байна. Европын зарим оронд төрөлтийн абсолют тоо нас баралтаасаа бага болж “**baby boomlet-төрөлтийн хомсдол**” ажиглагдаж байна. Эндээс, судлаачид “**Хоёр дахь хүн ам зүйн шилжилт**”-ийн талаар ярих боллоо.

Европын улс орнуудад ажиглагдсан төрөлтийн бууралтад аж үйлдвэржилт, эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн хөгжил гол үүрэг гүйцэтгэсэн ба засгийн газрын оролцоо харьцангуй бага байсан. Тэдний хувьд “гэр бүлийн норм” буюу зохистой гэж үздэг хүүхдийн тоо цөөн, гэр бүл төлөвлөлт (ГБТ)-ийн аргуудын мэдлэг, хэрэглээ харьцангуй жигд байсан тул нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалан төрөлт жигд буурсан байна.

Харин 1950-иад оноос эхэлсэн хөгжиж байгаа орнуудын хүн амын төрөлтийн бууралтад гол нөлөө үзүүлсэн хүчин зүйлс нь хүмүүсийн гэрлэлтийн нас хойшилсон, эмэгтэйчүүдийн боловсрол, жирэмслэлтээ төлөвлөх чадавхид ахиц гарсан, хүүхдийн нас баралт буурсан, засгийн газрууд ГБТ-ийн аргуудыг илүү боломжтой, хүртээмжтэй болгох бодлогуудыг баримталж эхэлсэн зэрэг хүчин зүйлүүд юм. Ялангуяа, гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүдийг хөгжиж байгаа орнуудын засгийн газрууд өөрсдөө хүчин чармайлт гарган хэрэгжүүлсэн нь ихээхэн нөлөө үзүүлсэн гэж үздэг.

Боловсролын түвшин дээшилсэн нь мөн эмэгтэйчүүдийг төрөлтөө хязгаарлах хүчин зүйл байсан. Залуу насны эмэгтэйчүүд илүүтэйгээр боловсролд хамрагддаг ба хөгжиж буй орнуудад эмэгтэйчүүдийн боловсрол дээшилснээр цөөн тооны, “чанартай” хүүхдийг эрхэмлэх болсон. Тэдний гэрлэх нас хойшилж, ГБТ-ийн аргын хэрэглээ нэмэгдсэнээр төрөлт буурч байна.

Хосууд урьд үеийнхнээсээ цөөн хүүхэдтэй байхыг эрмэлзэх болсон, албан ёсны гэрлэлт нь хамтран амьдрах хэлбэр рүү шилжиж байгаа зэрэг өнөөгийн нийгэмд гарч ирж байгаа шинэ хандлагууд нь ч дээрх хүчин зүйлсээс дутахааргүйгээр төрөлтийн цаашдын түвшинд тодорхой нөлөө үзүүлнэ хэмээн судлаачид таамаглаж байна. Ийнхүү төрөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэн, тэдгээрээр дамжуулан бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч

нар хүн амын өсөлт, төрөлтөд нөлөөлөх бодлогоо хэрэгжүүлэх боломжтой.

Судлаачид “**Хоёр дахь хүн ам зүйн шилжилт**”-ийг (төрөлт нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшингээс доогуур түвшинд хүрсэнтэй холбоотойгоор анх гарсан ойлголт) Европын хүн амын дунд “**фамилизм-family oriented lifestyle**”-ын эсрэг үзэгдэл болох “**индивидуализм**” тархсантай холбон тайлбарлаж байна. Энэ нь тэдгээр орнуудад албан ёсны гэрлэлт нь хамтран амьдрах хэлбэр рүү шилжиж байгаа, гэр бүл салалтын түвшин нэмэгдэж байгаа (Итали, АНУ), хосууд “**нөхөн үржихүйн хэрэгцээ**”-нээсээ илүү “**нийгмийн хэрэгцээ**”-гээ түрүүнд тавьж урьд үеийнхнээсээ цөөн хүүхэдтэй байхыг эрмэлзэх болсон зэрэг хандлагуудаар илэрч байна. Өөрөөр хэлбэл, тэдгээр орнууд дахь төрөлтийн түвшингийн түүхэн хандлага нь: анх эдийн засгийн ба эдийн засгийн бус хэрэгцээнд үндэслэсэн төрөлт зонхилж байсан бол яваандаа эдийн засгийн бус хэрэгцээнд үндэслэсэн, одоо харин “**индивидуализм**”-д үндэслэсэн төрөлт зонхилж байгаа нь харагдаж байна.

Ийнхүү дэлхийн улс орнуудад төрөлтийн шилжилт явагдаж, төрөлтийн доогуур түвшин нь хүн амын дунд насжилтийн үйл явцыг нэмэгдүүлж, хүн амын тоо цаашид буурах нөхцөл болж, улс орнууд өөр өөрийн онцлогийг тусгасан, ялгаатай бодлогууд авч хэрэгжүүлж байгаа ба үр дүн нь ч хэрэгжүүлж буй арга хэлбэрээсээ хамааран харилцан адилгүй байна.

ТӨРӨЛТИЙН ТҮВШНИЙ ТАЛААРХ ЗАСГИЙН ГАЗРУУДЫН БАЙР СУУРЬ, ХАНДЛАГА

Төрөлтийн талаарх бодлого гэдэг нь засгийн газраас хувь хүн, гэр бүлүүдийн төрөлтийн тоонд нөлөөлөх зорилгоор авч хэрэгжүүлж буй шууд болон шууд бус арга хэмжээнүүдийн цогц юм. Төрөлтийн талаарх бодлого нь засгийн газруудын хүн амын бодлогын нэг үндсэн хэсэг нь байдаг бөгөөд хүн амын тоо хэмжээ, өсөлт бүтцэд нөлөөлөх эцсийн зорилготой.

Хувь хүн, гэр бүлийн төрөлтийн талаарх шийдвэрт Засгийн газар нийгэм, эдийн засгийн болон бусад янз бүрийн арга механизмаар дамжуулан нөлөө үзүүлдэг.

Хэрэв засгийн газар хууль, бодлого, хөтөлбөр батлахдаа хувь хүн, хосуудын гэрлэлт, жирэмслэхээс сэргийлэх хэрэгслийн хэрэглээ, хүүхдээ хөхөөр тэжээх практик, үр хөндөлтийн түвшин зэрэгт (төрөлтийн түвшинг тодорхойлогч завсрын хүчин зүйлс) шууд нөлөөлөх замаар төрөлтийн түвшинг өөрчилж байвал тэр нь төрөлтөд нөлөөлж буй шууд нөлөөлөл, харин засгийн газрын бодлогоороо дамжуулан хувь хүн, хосуудын нийгэм, эдийн засгийн байдалд нь нөлөөлж байвал шууд бус нөлөөлөл гэдэг. Олон улсын практикт төрөлтөд нөлөөлөх Засгийн газрын бодлогыг пронаталист ба антинаталист гэж 2 хуваан үздэг. Төрөлтийн тоог нэмэгдүүлэх замаар хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн засгийн газар, эсвэл ямар нэг нийгмийн бүлгийн бодлого болох пронаталист бодлогын талаар авч үзье.

Пронаталист бодлогууд нь нэлээд эртний гаралтай ба анх нас баралтын өндөр түвшин болон үндсэрхэг үзэл дээр тулгуурлан гарч ирсэн. Анх гарч ирэхдээ цэрэг дайны зорилгоор, эсвэл уугуул иргэд болон цэвэр цусны үндэстнүүдийн тоог их байлгах гэсэн аль нэг хувь улсын сонирхол дээр голлон үндэслэж байсан ба төрөлтийн хяналтыг эсэргүүцэж, хүүхэд төрүүлэхийг дэмжих, эхчүүдийг бэлэн мөнгөөр болон одон медалиар урамшуулах, гадагш шилжих хөдөлгөөнийг зохицуулах гэх мэт арга замаар хэрэгжиж байжээ. Тэр үеэс хойш буюу 1970-аад оноос уг бодлогын зорилго ихээхэн өөрчлөгдөж, эдийн засгийн урамшуулал, үр хөндөлт болон жирэмслэлтээс сэргийлэх аргуудын хэрэглээнд хязгаарлалт тавих зэрэг арга хэмжээнүүдийг өргөн хэрэглэх болсон байна.

Улс орнууд өөрсдийн үндсэрхэг үзэл, шашин, соёлын нөлөөгөөр төрөлтөө урамшуулахыг дэмжиж байж болох талтай ч үүнээс илүү хүчтэй байж болох шалтгаан бол төрөлтийн доогуур түвшин нь хүн амын насжилт, хүн амын тооны бууралтад хүргэж болно гэсэн дүгнэлт юм. Өнөөдөр төрөлтийн түвшин буурч байгаа улс орнууд түүнээс гарч болох сөрөг үр дагавруудыг дараах байдлаар гарган тавьж байна. Үүнд:

- Хүн амын насны бүтэц өөрчлөгдсөнөөр (хүн ам зүйн цонх хаагдах үед) цөөн тооны ажиллах хүчин харьцангуй

олон настнуудыг тэтгэх хэрэгтэй болох учраас тухайн улсын нийгмийн хамгааллын систем, тэтгэврийн төлөвлөлтөд хүндрэл учирна. Хүн амын насны бүтцэд төрөлтийн гүйцэтгэх үүргийг хэн бүхэн ойлгож байгаа боловч насжилт явагдаж байгаа олон оронд төрөлтөд маш бага анхаарал хандуулсан байдаг нь ажиглагджээ.

- Хөдөлмөрийн насны хүн ам урьд үеэс цөөрсөөр эдийн засгийн өсөлт удааширна.
- Хүн амын тооны бууралт нь үндэсний тусгаар тогтнолыг сулруулна гэх мэт.

Дээрх үзэгдлүүдийн сөрөг үр дагавраас сэргийлэх үүднээс зарим орнуудын засгийн газрууд шууд болон шууд бусаар төрөлтийг дэмжих, тухайлбал, хосуудын гэрлэлтийг дэмжих, олон хүүхэд төрүүлэхийг дэмжих, хөдөлмөрийн насны хүн амын шилжих хөдөлгөөнийг дэмжих, бодлогоо хүн амын насжилтын үр нөлөөнд чиглүүлэн шинэчлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Төрөлтийг дэмжих дээрх аргуудыг 3 үндсэн хэсэгт хуваан үзэж болох юм. Үүнд:

- Мөнгөн тэтгэмж/урамшуулал олгох,
- Эцэг эхчүүдэд ажил эрхлэх болон хүүхдээ өсгөхийг хослуулах боломжийг олгох,
- Эцэг эхчүүд, хүүхдүүдэд нийгмийн өөрчлөлтийг дагахад дэмжлэг үзүүлэх.

1. Мөнгөн тэтгэмж/урамшуулал олгох

Сар/улирлаар олгох хүүхдийн мөнгө

Энэ нь хүүхдэд олгох бүхий л төрлийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой зохицуулалт юм. Зарчмын хувьд хүүхэд бүрт зориулан олгож буй мөнгөн төлбөр гэсэн үг. Энэхүү тэтгэмж нь:

- Хүүхдийн насаар ялгаатай байж болно. Жишээ нь, хүүхдийн тэтгэмж нярай үед эсвэл хүүхэд өсөж илүү зардал гаргах болсон үед өндөр байж болно.
- Төрөлтийн дарааллаар ялгаатай байж болно. Төрөлтийг дэмжих бодлого

баримталж буй тохиолдолд анхны хүүхдээс илүү 2 дахь, 3 дахь хүүхдэд илүү мөнгөн тэтгэмж олгох нь илүү үр дүнтэй. Учир нь хосууд гэр бүлтэй болсноор ядаж нэг хүүхэдтэй болох өндөр магадлалтай учир 2 дахь, 3 дахь хүүхдэд мөнгөн тэтгэмж олгосноор төрөлтийг илүү дэмжинэ гэсэн үг.

Нэг удаагийн тэтгэмж/зээл

Энэ нь хүүхэд төрөхөд (төрсөн хүүхдийн bonus, эхийн тэтгэмж) олгох тэтгэмж болон шинээр гэр бүл бологсод олгох нэг удаагийн тэтгэмж юм. Залуу гэр бүлд олгож буй хөнгөлттэй зээл эсвэл хүүхэд сургуульд ороход олгох зээлийг мөн багтааж болно. Энэхүү нэг удаагийн тэтгэмж/зээлээс хүртэх ашиг нь төрөлтийн шийдвэрт нөлөөлөхүйц байх шаардлагатай. Тухайлбал, залуу гэр бүлд орон сууцны зээл олгох нь дээд сургуулийн боловсролыг үнэгүй болгосноос илүү нөлөөтэй гэсэн үг.

Татварын хөнгөлөлт, татвараас чөлөөлөх

Энд хүүхэдтэй болсонтой холбоотой татварын хөнгөлөлт, татвараас чөлөөлөхийг багтаах ба дээр дурьдсанчлан хүүхдийн нас, төрөлтийн дарааллаар ялгаатай байвал үр дүнтэй. Англи улс “ажил эрхэлж буй гэр бүлийн татварын хөнгөлөлт”, Австрали улс “хүүхэдтэй гэр бүлийн татварын хөнгөлөлт”-ийг нэвтрүүлжээ. Татварын хөнгөлөлтийг нэвтрүүлсэн туршлагатай орнуудын нэг бол Сингапур улс юм. Энэ улсад 32 нас хүрээгүй, 2 хүүхэдтэй эхэд татварын хөнгөлөлтийг маш их хэмжээгээр тодруулбал, хэрэв 2 дахь хүүхэд нь 28 наснаас өмнө төрсөн тохиолдолд \$20,000 (Сингапур доллар) –тай тэнцэх хэмжээний хөнгөлөлт, 3 дахь, 4 дэх хүүхдээ төрүүлсэн эхэд нэмэлт хөнгөлөлтүүд олгодог ба энэхүү татварын хөнгөлөлтийг хүүхэд төрснөөс хойш 9 жилийн хугацаанд олгодог байна.

Хүүхдэд зориулсан үнэгүй/хөнгөлттэй бараа үйлчилгээнүүд

Мөнгөн тэтгэмж олгох эсвэл татвараас чөлөөлөхөөс илүү хүүхдэд зориулсан үнэгүй эсвэл хөнгөлттэй бараа үйлчилгээнүүд илүү үр дүнтэй байдаг. Үүнд бүх шатны боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй олгох, нийтийн тээврээр зорчих, спорт, үзвэр үйлчилгээ зэрэг амралт чөлөөт

цагийг зөв өнгөрөөхөд хөнгөлөлт үзүүлэх зэргийг оруулна. Түүнчлэн хичээлийн хэрэгсэл, спортын багаж төхөөрөмжийг үнэгүй олгох, цахилгаан, бензин, автомашины бүртгэл, даатгал зэрэгт хөнгөлөлт үзүүлэхийг багтааж болно. Эдгээр үйлчилгээ нь эргээд хүүхдийн тоо, насаар ялгаатай байвал үр дүнтэй.

Орон сууцны төлбөрийг хөнгөлөх

Европын орнуудад хийгдсэн судалгаагаар гэр бүлтэй болоход хамгийн гол нөлөөлдөг зүйл нь орон сууцны зардал гэсэн үр дүн гарчээ. Жишээ нь, Австри улсад хийгдсэн хүн амын бодлогыг дэмжих судалгаанд оролцсон 20-39 настай залуучуудын гуравны нэг нь орон сууцны асуудал хүүхэдтэй эсвэл дахин хүүхэдтэй болохгүй байх гол шалтгаан байсан гэжээ. Иймд орон сууцны асуудлыг анхааран авч үзэх шаардлагатай. Үүнд орон сууцтай болоход зориулан мөнгөн тэтгэмжийг сар/улирлаар олгох, нэг удаагийн мөнгөн тэтгэлэг олгох (эхлээд байр худалдан авах зориулан мөнгөн тэтгэмж олгох дараа нь хүүхдийн тооноос хамааруулан орон сууцны зээлийн хүүг бууруулах), орон сууцны татвараас чөлөөлөх/хөнгөлөх, орон сууцтай холбоотой бусад үйлчилгээнд хөнгөлөлт үзүүлэх зэргийг хамруулдаг. Хэрвээ орон сууц худалдан авахад татвар төлдөг бол татвараас чөлөөлөх, Засгийн газраас хүүхэдтэй гэр бүлд зориулан нийтийн орон сууц барих, орон сууцны зээлийн хүүг бууруулах, хугацааг нь уртасгах боломжууд байж болно. Түүнчлэн, орон сууц барьж буй компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэх, эсвэл Засгийн газраас байрны үнийн өсөлтөд хяналт тавих боломж байж болно.

2. Ажил, гэр бүлийн асуудлаа хослуулах боломжийг олгох

Эцэг, эхэд чөлөө олгох

Эцэг эхэд ажлын чөлөө олгосноор ажил, гэр бүлийн асуудлаа хослуулах боломжийг олгодог. Ийм төрлийн бодлогыг авч хэрэгжүүлж байгаа үед чөлөөний хугацаа ямар байх, чөлөөг хэзээ олгох, чөлөө олгож буй тохиолдолд цалинтай байх эсэх, эцэг, эхийн хэнд нь ямар хугацаатайгаар чөлөөг олгох, эцгүүдэд хүчээр чөлөө олгох ёстой эсэх, хагас цагийн ажил эрхэлж болох эсэх

гээд маш олон төрлийн асуудлууд гардаг. Жишээ нь, Норвегид чөлөө олгохдоо хагас цагаар ажиллах боломжийг давхар олгодог байна. Норвеги улсын хосуудад ажил, гэр бүлээ хослуулах боломж олгож буй энэ арга нь санхүүгийн урамшуулал олгохоос илүү үр дүнтэй гэж зарим судлаачид үздэг. Хэрэв чөлөөг цалинтай олгодог бол цалинг ажил олгогчоос уу, нийгмийн даатгалаас уу, аль эсвэл Засгийн газраас уу гэсэн асуулт гарна.

Хэрэв эцэг эхийн аль аль нь хүүхэд төрөх үед ажилгүй байсан бол тэдэнд зориулан ямар тэтгэлэг эсвэл чөлөө олгох вэ? Европын холбооноос эцэг эхэд олгож буй чөлөөний хамгийн доогуур түвшинтэй тэнцэхүйц хэмжээний тэтгэлгийг тогтоожээ. Чөлөөний хугацааны хувьд хүүхдийг асрахад нэг жилээс илүү гурван жил хүртэлх хугацааны чөлөөг олгох нь үр дүнтэй гэсэн баримтууд байна. Үүнийг 1980 оноос хэрэгжүүлсэн Шведийн хүн амын бодлого, 1990 оноос хэрэгжүүлсэн Францын хүн амын бодлогын жишээнээс харж болно.

Хүүхэд асрах үйлчилгээ

Энэ хэсгийн бас нэгэн чухал арга хэмжээ нь хүүхэд асрах үйлчилгээ юм. Энэ аргыг Франц, Норвеги, Швед орнууд зэрэг орнууд өргөн хэрэглэж байна. Сингапур улс гаднаас хүүхэд асрагч авахыг дэмждэг бол АНУ-д бага орлоготой, бичиг баримтгүй шилжигчид хүүхэд асрах үйлчилгээг үзүүлдэг.

Гэр бүлийн асуудлаар ажлын цагаас түр хугацааны чөлөө олгох

Гэр бүлийн асуудлаар чөлөө олгох талаар ажил олгогч болон ажилчдын хооронд зөвшөлцөөн байж болно. Жишээ нь, Норвегид бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд ажлын цагийн 80 хүртэл хувиар чөлөө авах эрхтэй байдаг. Мөн хүүхэд өвдөх, сургуультай холбоотой арга хэмжээнд оролцох зэрэгт түр хугацааны чөлөөг олгох хэрэгтэй. Хэрэв гэртээ ажлаа хийж болохоор байвал бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд гэртээ ажиллах боломж олгож болох юм.

3. Нийгмийн өөрчлөлтийг дагахад дэмжлэг үзүүлэх

Ажлын байрыг хадгалах

Жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн ажлын байрны баталгаатай байдлыг хангах, өөрөөр хэлбэл, хүүхэд төрүүлсний дараа ажилдаа эргэн орох нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Ажлын байрны баталгаатай байдал үйлчилгээний салбарт ажиллагчдын хувьд илүү хамааралтай байдаг байна.

Хүүхдэд ээлтэй орчин

Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Үүнд аюулгүй амьдрах орчин, амралт чөлөөт цагийг өнгөрөөх тоглоомын талбай барих, үзвэр үйлчилгээ, худалдааны төвүүд зэргийг нэрлэж болно. Эцэг эхчүүдийн ажил гэртэйгээ ойр байж хосууд ажил, гэр бүлээ хослуулах боломжийг олгох нөхцлийг ч оруулж болно. Мөн хүүхдийн цэцэрлэг, сургууль ойр байх нь чухал. Иймд, хүүхдэд ээлтэй хот төлөвлөлт нь пронаталист бодлого байх болно.

Жендэрийн тэгш байдал

Өрх гэр бүл дэх ажлын хуваарилалт маш чухал. Өрх гэрийн тэргүүн тэжээгч гэдэг ойлголтоос салж гэр бүлдээ эцэг эх байхын хариуцлагыг ухамсарлан хүүхдээ өсгөхөд оролцох ёстой. Өөрөөр хэлбэл, “эцэг”-ийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн үг. Жендэрийн тэгш байдал Европын хүн амын төрөлтийн бодлогод нэлээд хөндөгдсөн байдаг.

Гэрлэлтийг дэмжих

Төрөлтийн бууралтанд нөлөөлж буй гол хүчин зүйлийн нэг нь гэрлэлтэд гарч буй өөрчлөлт гэдэг нь тодорхой. Гэрлэх нас хойшилж байгаа, албан ёсны гэрлэлтээс хамтран амьдрах хэлбэрт шилжиж байгаа зэрэг өөрчлөлтүүдийг нэрлэж болно. Сингапурын Засгийн газраас залуучуудыг танилцуулах үдэшлэгийг зохион байгуулдаг бөгөөд гэрлэгчдэд мөнгөн тэтгэмж олгох, орон сууцаар хангах зэрэг арга хэмжээг авч байна. Эрт гэрлэсэнээр эрт хүүхэдтэй болох ба 2 дахь, 3 дахь хүүхэдтэй болох боломж байна гэсэн үг.

Орчин үед нэлээд хэдэн орон пронаталист бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд тэд тус бүрдээ ялгаатай шалтгаан, арга хэрэгсэлтэй байна. Жишээ болгож, зарим улсуудын бодлого хэрэгжүүлсэн туршлагаас¹⁴ авч үзье.

- Зүүн Герман 1976 онд хүн амынхаа төрөлтийн түвшинг нэмэгдүүлэх үүднээс хүүхэд асрах үйлчилгээг сайжруулах, санхүүгийн урамшуулал, төрөөс орон сууцны асуудалд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг багтаасан бодлого боловсруулан хэрэгжүүлжээ. Үүний үр дүнд Баруун Германтай бараг адилхан түвшинд буураад байсан ТНК нь 1,5-аас 1,9 болж өссөн ба хүүхэд төрүүлэх дундаж нас Баруун Германд 28 болж нэмэгдсэн байхад Зүүн Германд 25 хэвээрээ хадгалагдаж чаджээ. Гэвч яг тухайн үед Баруун Европт пронаталист бодлогыг эсэргүүцсэн олон нийтийн хандлага гарч ирсэн байна. Үүний учир нь *нэгдүгээрт*, төрөлтийг дэмжих пронаталист бодлого өнгөрсөн фашизмын дэглэмийн үед хэрэгжихдээ нэр хүнд нь ихээхэн унасан байсан, *хоёрдугаарт*, хүүхэд төрүүлэх нь эмэгтэйчүүд статусаа дээшлүүлэхэд ихээхэн саад болдог гэсэн үзэл ихээхэн тархсан байжээ. Тэгвэл, өнөөгийн Европ дахь гэр бүлийн бодлогууд нь “ижил боломж бүрдүүлэх” гэсэн зарчимд үндэслэх болсон ба хүүхдээ асрахыг ажил эрхлэлттэйгээ хослуулах боломжийг эмэгтэйчүүдэд олгоход анхаарч байна.
- Швед бол төрөлтийн түвшингээрээ дэлхийд хамгийн доогуур орж байгаа Хойд Европын орнуудын нэг бөгөөд төрөлтөө нэмэгдүүлэхэд чиглэсэн идэвхтэй бодлого баримталж буй орон юм. Шведийн баримталж буй пронаталист бодлогын гол онцлог нь гэр бүл, хосуудын төрөлтийг дэмжихдээ хувь хүний сонголт, эрх чөлөөг нь дээд зэргээр анхааран үздэг явдал гэж болно. Түүхийн хуудсыг сөхөн үзвэл, Шведийн засгийн газар шинээр эцэг,

¹⁴ МУИС, ХАССТ, 2005. “Хүн амын бодлого” сурах бичиг, Хүн Амын Сургалт Судалгааны Төв, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар

эх болж буй хүмүүст хоёуланд нь жил хүртэлх хугацаанд урамшуулал өгөх, хагас өдрөөр ажиллах, чөлөө авах боломж олгох гэх зэргээр ажлын байрны уян хатан зохицуулалтыг хуулиар баталгаажуулан тодорхой хугацаанд хэрэгжүүлж үзсэн ба энэ нь төрөлтийн түвшинг нэмэгдүүлэхэд зохих үр дүнгээ өгчээ. Гэвч дээрх арга хэмжээ нь улсын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх болсноор төрөлтийг дэмжсэний үр ашиг нь гараагүй гэж болно. Тийнхүү санхүүгийн дэмжлэгийг болиулсны дараа төрөлтийн түвшин шууд эрс буурсан ба энэ бууралт ердөө арваадхан жилд болж өнгөрчээ. Эндээс, аливаа хүн амын бодлого нь ямагт хүлээгдэж байгаагүй эерэг, эсвэл сөрөг үр дагавруудыг давхар дагуулж байдаг нь тод харагдаж байна.

- Унгар болон Румын улсууд мөн пронаталист бодлогыг хэрэгжүүлж буй Зүүн Европын орнууд юм. Унгарт хүүхдүүдэд нь сар бүр тэтгэмж өгөх, эхчүүдэд жирэмсний болон хүүхэд асрах цалинтай чөлөө өгөх, хүүхдэд зориулсан бараа, үйлчилгээний үнэнд хөнгөлөлт үзүүлэх, хүүхдийн тооноос хамааруулан өрхийн сууцны төлбөрийг хөнгөлөх, жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн ажлын байрыг хадгалах гэх зэргээр хүүхэд төрүүлэхийг дэмжсэн маш олон төрлийн эдийн засгийн урамшууллын арга хэмжээг бодлогоо хэрэгжүүлэхдээ ашиглаж байв. Түүнчлэн, үр хөндөлтөд 1974 оноос хязгаарлалт тавьсан боловч жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслүүд өргөн нэвтэрч, хэрэглээ нь нэмэгдсэн байна. Румын улс үр хөндөлт болон жирэмслэлтээс сэргийлэх аргуудын хэрэглээнд хоёуланд нь хязгаарлалт тавих (жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргуудыг зөвхөн эмнэлгийн заалтаар л хэрэглэхийг зөвшөөрөх) замаар төрөлтөө дэмжих бодлого хэрэгжүүлж байжээ.

Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино гэж заажээ.

Өнөөгийн хуулиар эх, хүүхдэд тэтгэмж олгох, шинээр гэрлэгчид болон төрсөн хүүхдэд тэтгэмж олгох, “Эхийн алдар” нэг, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэхтэй холбогдсон харилцааг зэргийг зохицуулж байна.

Хүн амын өсөлтийг дэмжих бодлого баримталж буй орнуудын туршлагаас харахад хосуудын төрөлтийг дэмжихдээ халамж, тэтгэмж гэх мэт эдийн засгийн урамшууллаас гадна хүүхэд асрах, өндөр настан, гэр бүлийнхнээ асрах, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны үйлчилгээнүүд зэрэг гэр бүл рүү чиглэсэн үйл ажиллагааг анхаарах нь илүү үр дүнтэй болох нь харагдаж байна. Нас баралтын түвшин буурч буй өнөө үед хүн амын өсөлтийг зөвхөн төрөлтийн түвшинг дэмжсэнээр хангах боломж байгаа тул манай орны хувьд хүн амын бодлогоо эргэн харж, төрөлтийг дэмжиж буй улс орнуудын туршлагыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тодруулбал:

- Хүүхдийн тэтгэмжийг олгохдоо хүүхдийн нас, хүүхдийн тоогоор ялгаатайгаар олгох (2 дахь, 3 дахь хүүхдэд ялгаатай, насны ангиллаар ялгаатай);
- Шинээр төрсөн хүүхдэд олгох мөнгийг төрөлтийн дараалаар ялгаатай олгох (2 дахь, 3 дахь хүүхдэд ялгаатай);
- Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд анхаарах. Үүнд: Хүүхэд аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүүхдэд зориулсан үнэгүй эсвэл зарим хөнгөлттэй бараа үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх, хүүхэд асрах, цэцэрлэг, яслийн үйлчилгээг сайжруулах;
- Төрөөс орон сууцны асуудалд дэмжлэг үзүүлэх - залуу гэр бүл, олон хүүхэдтэй гэр бүлийг орон сууцны хөнгөлттэй, урт хугацааны зээлд хамруулах;
- Эхчүүдэд жирэмсний болон хүүхэд асрах цалинтай чөлөө олгох. Хэрвээ хүсвэл эцэгт нь цалинтай чөлөө олгох;
- Эцэг эх байхын хариуцлагыг ухамсарлуулж, хүүхэд асрахад “эцэг”-ийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжийг харгалзан үзэх хэрэгтэй.